



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2023.03.15 № 07/547  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Далайн захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Далайн захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 200.3 сая төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.6.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1, 12.2.1, 13.6, 13.7, 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.2 дахь заалтууд болон санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Усан замын тээврийн салбарын 70 жилийн ойн арга хэмжээнд 77.1 сая төгрөг зарцуулсан;
- Дээд шатны байгууллагын албан тушаалтнуудын АНУ болон БНСолонгос улс руу явсан гадаад томилолтын зардлын 33.4 сая төгрөгийг тус байгууллагын хөрөнгөөс зарцуулсан;
- Жолоочийн шатахууны 32.8 сая төгрөгийн тооцоо хийгээгүй;

### Онцлох асуудлын хэсэг

Далайн захиргаа ТӨҮГ болон “Монголын хөлөг онгоцны бүртгэл” хамтарсан компанийн 2017-2020 оны үйл ажиллагаанд 2020 оны 12 дугаар сарын 15-наас 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрүүдэд Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яамны 14 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Гадаад харилцааны дэд сайдаар ахлуулан хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийсэн байна. Дотоод аудитын тайланд:

- Далайн захиргаа ТӨҮГ нь “Монголын хөлөг онгоцны бүртгэл” компаниас үйл ажиллагааны зардалд 2017-2020 онд 1.4 сая ам.доллар буюу 3.6 тэрбум төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэхээр 831 ам.доллар буюу 2.1 тэрбум төгрөгийг авсан ч тухайн хугацаанд улсын төсөвт 832.0 сая төгрөг төвлөрүүлж, дээд шатны захирагчийн шийдвэргүйгээр үйл ажиллагаандаа зарцуулсан;
- Монголын хөлөг онгоцны бүртгэл компани 2015-2020 оны цэвэр ашгаас 942.0 мянган ам.долларыг монголын талд хувьцааны ногдол ашиг шилжүүлэхээс нийт 499.0 мянган ам.доллар буюу 1.3 тэрбум төгрөгийг олгож, 483.0 мянган ам.доллар буюу 1.2 тэрбум төгрөгийн ноогдол ашгийг монголын талд олгоогүй зөрчил илрүүлснийг дүгнэлт хэсэгт тусгаагүй, зөвлөмж өгөөгүй, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналд уг асуудлын талаар тусгаагүй орхигдуулжээ. Аудитын тайлан нь Далайн захиргаанд баталгаажиж ирээгүй, цахимаар ирсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/58 тушаалаар батлагдсан бүртгэлийн үйлчилгээний тарифын дагуу үйлчилгээний орлогыг тооцож, нэхэмжилдэг байна. Үүнээс өмнө албан ёсны үнийн тарифгүй байсан байна. Далайн захиргаа ТӨҮГ нь хөлөг онгоц эзэмшигч бүртэй ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулдаггүй, харин 5 зуучлагчтай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Байгууллагын зорилтот түвшний төлөвлөгөөнд орлого 1,428.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, нийт зардлыг 2,409.9 сая төгрөгөөр баталж, зардлын эх үүсвэрийн дутагдлыг мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр үндсэн болон бусад үйл ажиллагааны орлогоос 3,640.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,922.1 сая төгрөг зарцуулж, 1,718.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд зорилтын хүрээнд 69 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 83.8 хувь гэж үнэлсэн байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

